

ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Дорноговь АЗЗА ТӨХК-ийн 2019 оны санхүүгийн тайлангийн
аудит

Аудитын код: ДГА-2020/1/СТА-ТӨҮГ

Цахим хуудас: www.audit.mn
(Дорноговь аймаг, Сайншанд сум)
2020 он

Тэргүүлэх аудитор:	Ч.Ариунаа
Утас: 70522734	Цахим хаяг: ariunaa.ch@audit.gov.mn
Аудитын менежер:	Э.Энхцэцэг
Утас: 70523020	Цахим хаяг: enkhtsetseg.e@audit.gov.mn.
Аудитор:	Г.Энхтөр
Утас: 99032916	Цахим хаяг: ij17.audit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НББОУС	Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	3
2	Аудитын тайлан.....	5
2.1.	Оршил.....	5
2.2.	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3.	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	6
2.4.	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	6
2.5.	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	7
2.6.	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	8
2.7.	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	8
2.8.	Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	8
2.9.	Үйл ажиллагааны орлого, зардлын төсөв, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга ...	9
2.10.	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	10
2.10.1	Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээлэл	10
2.11.	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	10
2.12.	Шилэн дансны мэдээлэл	11
2.13.	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	11
2.14.	Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	11
3	Менежментийн захидал	12
4	Аудит хийгдсэн санхүүгийн тайлан	Error! Bookmark not defined.

1 Аудитын гэрчилгээ


 ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР 44103 Дорноговь аймаг, Сайншанд сум, 3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр, Утас: (705) 2-27-34 Бүх сайр: dornogovi@audit.gov.mn	ДОРНОГОВЬ АЗЗА ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ А.БАТТОГТОХ ТАНАА
2020.03.13 № 1-6/326 танай _____ -ны № _____ -т _____	
Аудитын гэрчилгээ	
Монгол Улсын Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Дорноговь АЗЗА ТӨХК-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.	
Зөрчилгүй санал дүгнэлт Дорноговь АЗЗА ТӨХК-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайлангуудыг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн стандарт болон холбогдох хууль, тогтоомжийн дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.	
Санал дүгнэлтийн үндэслэл Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг. Аудитаар Дорноговь АЗЗА ТӨХК-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан. Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.	

Үүрэг, хариуцлага

Дорноговь АЗЗА ТӨХК нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Ч.АРИУНАА

2 Аудитын тайлан

2.1. Оршил

Дорноговь аймгийн Дорноговь АЗЗА ТӨХК-ийн 2019 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан, дүгнэлтийг гүйцэтгэх захирал А.Баттогтоход танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Дорноговь АЗЗА ТӨХК-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайланд аудит хийлээ.

Дорноговь аймгийн Дорноговь АЗЗА ТӨХК-ийн 2019 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Дорноговь аймгийн Дорноговь АЗЗА ТӨХК-ийн удирдлага нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг НББОУС, СТОУС/УСНББОУС болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайланг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 2 дугаар сарын 11-ээс 2020 оны 3 дугаар сарын 10-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 3 дугаар сарын 15-ны өдөр эцэслэн баталгаажуулж, байгууллагын удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газрын захиалгаар Ингүүмэл жаргалант аудит ХХК хариуцаж хэрэгжүүлэв.

Дорноговь аймгийн Дорноговь АЗЗА ТӨХК-ийн 2019 оны санхүүгийн тайланг Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 2 дугаар сарын 10-ны өдрийн 32 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, СТОУС,НББОУС, УСНББОУС, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Дорноговь аймгийн Дорноговь АЗЗА ТӨХК-ийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Дорноговь аймгийн Дорноговь АЗЗА ТӨХК нь "Зөв төлөвлөлт, чанартай бүтээн байгуулалт, үр дүнтэй хяналт" гэсэн зорилтын хүрээнд төрийн захиргааны байгууллагаас баталгаажуулсан улсын чанартай авто зам, замын байгууламжийн засвар, арчлалтыг хариуцсан замын хэмжээнд зохион байгуулж түүгээр өнгөрч байгаа тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг жилийн 4 улирлын туршид бүрэн хангах гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Компаний үүсгэн байгуулах баримт бичигт зааснаар үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Авто замын байгууламжийг барих, засварлах.

Монгол улсын "Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай" хуулийн 15 дугаар зүйлийн 15.15.4 заалт, "Авто замын тухай" хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 13 дугаар зүйлийн 13.1 дэх заалтуудын дагуу олгосон 2017/047 тоот тусгай зөвшөөрөлд дараах ажил, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг 2017 оны 5 дугаар сарын 24-ний өдрөөс гурван жилийн хугацаатай олгосон байна. Үүнд:

- Хатуу хучилттай зам барих.

- Хайрган хучилттай зам барих
- Хатуу болон хайрган хучилттай зам барих
- Төмөр бетон, ган төмөр, модон гүүр засварлах
- Зам, замын байгууламжид хамаарах талбай барих, засварлах
- Үерийн хамгаалалтын далан барих
- Тавилан барих, засварлах

Компаний үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Дорноговь аймгийн Дорноговь АЗЗА ТӨХК-ийн удирдлага дараах хууль болон Сангийн сайдын баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Авто замын тухай хууль
- Компаний тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Нийгмийн даатгалын тухай хууль
- Татварын багц хуулиуд

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагааг зохицуулж байгаа эрх зүйн орчинд томоохон өөрчлөлт гараагүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Дорноговь аймгийн Дорноговь АЗЗА ТӨХК-ийн Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцээгүй байна.

Компани 2015 онд ММНБИ-ийн Дорноговь дахь салбарын боловсруулсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж байгаа боловч компаний удирдлагаар батлуулаагүй, үндэслэл болгосон зарим хууль, заавар, журам одоо хүчингүй болсон байна.

Дорноговь аймгийн Дорноговь АЗЗА ТӨХК-ийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагааг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Дорноговь аймгийн Дорноговь АЗЗА ТӨХК-ийн санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн Санхүүгийн тооцоолох групп ХХК-ийн "Leader" программ хангамж ашигладаг байна.

Дорноговь аймгийн Дорноговь АЗЗА ТӨХК-ийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 39 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 2 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогыг сонгож материаллаг байдлын түвшинг 1 хувиар сонгов.

Нийт орлогыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь орлогоороо зардлаа санхүүжүүлж байгаатай холбоотой юм.

Дорноговь аймгийн Дорноговь АЗЗА ТӨХК-ийн 2019 оны нийт орлого 1,354,242.7 мянган төгрөг бөгөөд түүний 1 хувь болох 13,542.4 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 1 хувиар тооцсон нь үйл ажиллагааны цар хүрээтэй холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Дорноговь аймгийн Дорноговь АЗЗА ТӨХК-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 79,503.4 мянган төгрөгөөр буюу 4.7 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс өссөн буюу материаллаг өөрчлөлт гарсан урьдчилж төлсөн зардал, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөрийн данснууд байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	91,466.30	53,448.70	(38,017.60)
Авлага	307,246.40	88,032.50	(219,213.90)
УТЗ		433,193.30	433,193.30
Бараа материал	280,700.10	481,804.80	201,104.70
Үндсэн хөрөнгө	989,679.40	692,116.30	(297,563.10)
Нийт хөрөнгө	1,669,092.20	1,748,595.60	79,503.40
Өр төлбөр	19,919.50	250,331.70	230,412.20
Хувь нийлүүлсэн хөрөнгө	1,259,316.60	1,259,316.60	-
Нэмж төлөгдсөн капитал	31,497.80	31,497.80	-
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	442,494.40	283,470.70	(159,023.70)
Эзэмшигчийн өмчийн бусад хэсэг	104,036.80	104,036.80	-
Хуримтлагдсан ашиг	(188,172.90)	(180,058.00)	8,114.90
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,669,092.20	1,748,595.60	79,503.40

Авлага дансны бууралт нь Зам тээврийн хөгжлийн төвөөс авах 2017 оны авлага 33,000.0 мянган төгрөгийн, Дорноговь аймгийн хөрөнгө оруулалтаар 2018 онд гүйцэтгэсэн авто замын ажлын хөлс болох 167,900.0 мянган төгрөгийн авлагыг тус тус барагдуулсантай холбоотой байна.

Өглөг дансны өсөлт нь дараах байдалтай байна. Үүнд:

- НДШ-ийн өглөг 14,300.0 мянган төгрөг
- НӨАТ-ийн өглөг 35,600.0 мянган төгрөг
- ХХОАТ-ын өглөг 18,300.0 мянган төгрөг
- Шатах тослох материал, бараа материалын үнийн өглөг 182,400.0 мянган төгрөг тус тус байна.

Урьдчилж төлсөн зардал дансанд төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн ажлын зардал /гүйцэтгэл/ байгаа бөгөөд аймгийн 2020 оны төсөвт тусгагдсан байна.

Үндсэн хөрөнгө дансны бууралт нь тайлант хугацааны элэгдэлтэй холбоотой байна.

2.9. Үйл ажиллагааны орлого, зардлын төсөв, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Тайлант онд Зам тээврийн яамнаас улсын чанартай зам засвар, арчлалтын санхүүжилт 757,900.0 мянган төгрөг, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн авто замын ажилд 634,500.0 мянган төгрөг, бусад орлогоор 45,200.0 мянган төгрөг, хүүгийн орлого 2,700.0 мянган төгрөг буюу нийт 1,716,400.0 мянган төгрөгийн орлоготой ажилласан байна. Үндсэн үйл ажиллагаанд нийт 1,744,300.0 мянган төгрөгийг зарцуулж 7,800.0 мянган төгрөгийн ашигтай ажилласан байна. Үйл ажиллагааны зардлыг бүлэглэн авч үзвэл. Үүнд:

- Цалингийн зардал 415,800.0 мянган төгрөг /23,8%/
- НДШ-ийн зардал 103,600.0 мянган төгрөг /5,9%/
- Ашиглалтын зардал 19,800.0 мянган төгрөг /1,2%/
- Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгслийн зардал 586,000.0 мянган төгрөг /33,6%/
- Бараа, түүхий эд материалын зардал 387,400.0 мянган төгрөг /22,2%/
- Бусад зардал 109,400.0 мянган төгрөг тус тус байна.

2.10. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 18 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 7,321.0 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 6,855.0 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 7 зөвлөмж өгч байна.

Аудитаар илэрсэн мянган төгрөгийн алдаа, зөрчилд 7 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

Аудитаар дараах 466.0 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 466.0 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоолоо. Үүнд:

1. Тус компани анхан шатны баримтгүй 466.0 мянган төгрөгийн томилолтын зардал олгосон байна.
Энэ нь эрх ба үүрэг, бодитой оршин байх ба тодорхойлогдсон байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь:

Төлбөрийн акт тогтоох

2.10.1 Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээлэл

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах асуудлыг залруулан санхүүгийн тайланд тусгаж, удирдлагаар зөвшөөрүүлэн баталгаажуулав. Үүнд:

- 2019 онд худалдан авсан 990.0 мянган төгрөгийн үнэ бүхий санхүүгийн болон цалингийн программ хангамжийг байраа материал дансанд бүртгэснийг биет бус хөрөнгөөр ангилан бүртгэж залруулсан.
- 2018 онд 179,930.5 мянган төгрөгөөр үнэлэгдсэн газар эзэмших эрхийг үндсэн хөрөнгө ангиллаар бүртгэсэн байсныг биет бус хөрөнгөөр ангилан бүртгэсэн.
- Үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэлийг тулган элэгдлийн тооцооллыг анх ашиглалтанд орсон хугацаанаас эхлэн тооцоолж холбогдох залруулгыг хийсэн
- 2018 онд хийсэн хөрөнгийн дахин үнэлгээтэй холбогдуулан хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл дансны үлдэгдлийг тулган баталгаажуулж зөрүүг залруулсан

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Дараагийн аудитаар Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль болон холбогдох журмын хэрэгжилтыг авч үзэх нь зүйтэй байна.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Дорноговь аймгийн Дорноговь аймгийн Дорноговь АЗЗА ТӨХК нь шилэн дансны нэгдсэн www.shilendans.gov.mn цахим хуудсанд Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд зааснаар 149 мэдээлэл байршуулахаас 147 мэдээллийг хугацаанд нь, 1 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан бөгөөд 1 мэдээллийг байршуулаагүй байна.

2.13. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар 4 зөвлөмж өгөгдсөн бөгөөд зөвлөмжийн биелэлт 2019 оны жилийн эцсийн байдлаар 100 хувьтай байна.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Дорноговь аймгийн Дорноговь АЗЗА ТӨХК-ийн 2019 оны санхүүгийн тайланд аудит хийхдээ АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Дорноговь аймгийн Дорноговь АЗЗА ТӨХК-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тусгасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, стандартад нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидал АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтэд үндэслэсэн болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Зарим тохиолдолд бараа материалыг дотоодын зах зээлээс болон импортоор худалдан авахдаа холбогдох баримтыг хуульд заасан шаардлагын хэмжээнд бүрдүүлээгүй байна.
2. Тус компаний хөрөнгөнд бүртгэлтэй, Айраг суманд байрлах кемпийн барилгын газар нь иргэдийн өмчилж авсан газартай давхцсан бөгөөд дахин үнэлгээ хийгдээгүй, иргэд газраа чөлөөлүүлэхээр аймаг, сумын төр захиргааны байгууллагад удаа дараа хүсэлт гаргасан байна.
3. Үндсэн хөрөнгийн орлого, зарлагын хөдөлгөөнд холбогдох анхан шатны баримтыг хөтлөхдөө бараа материалын орлого, зарлагын баримт /НХМаягт БМ-2, 3/-г хөтөлдөг байна.
4. Ээлжийн амралт олгох тухай мэдэгдлийг Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын 2000 оны 166 тоот тушаалаар баталсан заавар, маягтын дагуу үнэн зөв хөтлөх бөгөөд нягтлан бодогч уг мэдэгдлийг үндэслэн ээлжийн амралтын тооцоо, олговрыг бодож холбогдох санхүүгийн баримтын хамт хадгална.
5. Цалин хөлсийг арилжааны банкаар дамжуулан олгохоор цалин олгох хүснэгт /НХМаягт ЦХ-5Б/-г 2 хувь үйлдэн 1 хувийг банкинд өгч нийт дүнгээр холбогдох банкны дансанд шилжүүлдэг байна. Гэвч байгууллагад үлдэх хувь дээр банк баримтыг хүлээн авсан тухай банкны ажилтан гарын үсэг зурж баталгаажуулаагүй байна.
6. Авто замын ойн арга хэмжээнд зориулан 5,000.0 мянган төгрөг зарцуулсан боловч бэлэн мөнгөний зарцуулалтын тайлан байхгүй байна.
7. Байгууллагын удирдлагын шийдвэрийн дагуу нягтлан бодогч бэлэн мөнгөний орлого, зарлагын баримт /НХМаягт МХ-1, 2/-г бичдэггүй өөрөөр хэлбэл 1, 2 дугаар гарын үсэг зурагдсан баримтгүй байхад мөнгөний нярав гүйлгээ хийдэг байна.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг холбогдох баримтын хамт Төрийн аудитын газарт 2020 оны 5 дугаар сарын 25-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

3.1 Дотоод аудит

3.1.1 Илрүүлэлт:

Зарим тохиолдолд бараа материалыг дотоодын зах зээлээс болон импортоор худалдан авахдаа холбогдох баримтыг хуульд заасан шаардлагын хэмжээнд бүрдүүлээгүй байна.

Энэ нь эрх ба үүрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.4 заалтыг зөрчсөн байна.

3.1.2 Эрсдэл:

Баримтгүй болон баримтын бүрдэлгүй орлого, зарлагын гүйлгээг хүлээн зөвшөөрч данс бүртгэлд тусгасан байх.

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.4 заалтыг мөрдөж ажиллах. Худалдан авалтад заавал Е-баримтыг авах нь зүйтэй.

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

3.2 Балансын данстай холбоотой асуудал.

3.2.1 Илрүүлэлт:

Тус компаний хөрөнгөнд бүртгэлтэй, Айраг суманд байрлах кемпийн барилгын газар нь иргэдийн өмчилж авсан газартай давхцсан бөгөөд дахин үнэлгээ хийгдээгүй, иргэд газраа чөлөөлүүлэхээр аймаг, сумын төр захиргааны байгууллагад удаа дараа хүсэлт гаргасан байна.

Энэ нь эрх ба үүрэг, бодитой орчин байх ба тодорхойлогдсон байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна НББОУС-16 /Өмч, барилга, тоног төхөөрөмж/-г зөрчсөн байна.

3.2.2 Эрсдэл:

Үндсэн хөрөнгийг ашиглах боломжгүй болох.

3.2.3 Өгсөн зөвлөмж:

Тус хөрөнгөтэй холбоотой бичиг баримтыг судлах, газрын өмчлөлтэй холбоотой баримтыг холбогдох иргэн, төрийн байгууллагаас гаргуулан авч ТУЗ-д танилцуулан цаашид хөрөнгийг хэрхэн ашиглах, газрын асуудлыг шийдвэрлүүлэх нь зүйтэй.

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа.

3.3.1 Илрүүлэлт:

Үндсэн хөрөнгийн орлого, зарлагын хөдөлгөөнд холбогдох анхан шатны баримтыг хөтлөхдөө бараа материалын орлого, зарлагын баримт /НХМаягт БМ-2, 3/-г хөтөлдөг байна.

Энэ нь толилуулга ба тодруулга батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 заалт, Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалыг тус тус зөрчсөн байна.

3.3.2 Эрсдэл:

Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн өөрчлөлтийг бараа материалын маягтаар тайлагнасан.

3.3.3 Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодогч Сангийн сайдын 2018 оны 100 тоот тушаалаар баталсан үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэл /ҮХ-1/-г хөтлөхдөө Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалаар баталсан анхан шатны баримт болох ҮХ-1, ҮХ-2, ҮХ-3, ҮХ-4 маягтуудыг үндэслэх бөгөөд дээрх бүртгэл, маягтуудыг холбогдох санхүүгийн баримтын хамт хадгална. Иймд Сангийн сайдын баталсан дээрх заавар маягтуудыг судлан үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах.

3.3.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

3.4 Тухайн байгууллага, салбартай холбоотой хууль эрх зүйн орчин

3.4.1 Илрүүлэлт:

Ээлжийн амралт олгох тухай мэдэгдлийг Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын 2000 оны 166 тоот тушаалаар баталсан заавар, маягтын дагуу хөтөлдөггүй байна.

Энэ нь үнэн зөв байх, бодитой оршин байх ба тодорхойлогдсон байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын 2000 оны 166 тоот тушаалыг зөрчсөн байна.

3.4.2 Эрсдэл:

Хууль журмын хэрэгжилтийг хангаагүй байх.

3.4.3 Өгсөн зөвлөмж:

Ээлжийн амралт олгох тухай мэдэгдлийг Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын 2000 оны 166 тоот тушаалаар баталсан заавар, маягтын дагуу үнэн зөв хөтлөх бөгөөд нягтлан бодогч уг мэдэгдлийг үндэслэн ээлжийн амралтын тооцоо, олговрыг бодож холбогдох санхүүгийн баримтын хамт хадгална.

3.4.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

3.5 Дотоод аудит

3.5.1 Илрүүлэлт:

Цалин хөлсийг арилжааны банкаар дамжуулан олгохоор цалин олгох хүснэгт /НХМаягт ЦХ-56/-г 2 хувь үйлдэн 1 хувийг банкинд өгч нийт дүнгээр холбогдох банкны дансанд шилжүүлдэг байна. Гэвч байгууллагад үлдэх хувь дээр банк баримтыг хүлээн авсан тухай банкны ажилтан гарын үсэг зурж баталгаажуулаагүй байна.

Энэ нь эрх ба үүрэг бодитой оршин байх ба тодорхойлогдсон байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн 13 дугаар зүйлийн 13.7 заалтыг зөрчсөн байна.

3.5.2 Эрсдэл:

Анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй байх

3.5.3 Өгсөн зөвлөмж:

Цалин олгох хүснэгт /НХМаягт ЦХ-5б/-н байгууллагад үлдэх хувь дээр банкны ажилтнаар хүлээн авсан тухай гарын үсэг зуруулж баталгаажуулж ажиллах.

3.5.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

3.6 Дотоод аудит

3.6.1 Илрүүлэлт:

Авто замын ойн арга хэмжээнд зориулан 5,000.0 мянган төгрөг зарцуулсан боловч бэлэн мөнгөний зарцуулалтын тайлан байхгүй байна.

Энэ нь иж бүрэн байх, эрх ба үүрэг, үнэн зөв байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6 заалтыг зөрчсөн байна.

3.6.2 Эрсдэл:

Дараа тайлан гаргаж өгөхөөр авсан бэлэн мөнгөний зарцуулалтыг анхан шатны баримт дутуу өөрөөр хэлбэл баримтаар нотлогдоогүй гүйлгээг бүртгэх.

3.6.3 Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6 "анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна" заалтыг мөрдөж ажиллах. Тайланг нөхөн гаргуулж хяналт тавих нь зүйтэй.

3.6.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

3.7 Дотоод аудит

3.7.1 Илрүүлэлт:

Байгууллагын удирдлагын шийдвэрийн дагуу нягтлан бодогч бэлэн мөнгөний орлого, зарлагын баримт /НХМаягт МХ-1, 2/-г бичдэггүй өөрөөр хэлбэл 1, 2 дугаар гарын үсэг зурагдсан баримтгүй байхад мөнгөний нярав гүйлгээ хийдэг байна.

Энэ нь эрх ба үүрэг, үнэн зөв байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 заалт, Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалыг тус тус зөрчсөн байна.

3.7.2 Эрсдэл:

Баримтгүй болон баримтын бүрдэлгүй орлого, зарлагын гүйлгээг хүлээн зөвшөөрч данс бүртгэлд тусгасан байх.

3.7.3 Өгсөн зөвлөмж:

Байгууллагын удирдлагын шийдвэрийн дагуу хариуцсан нягтлан бодогч бэлэн мөнгөний орлого, зарлагын баримтыг бичиж нэг, хоёрдугаар гарын үсэг зурагдсаны дараа мөнгөний нярав зохих гүйлгээг хийх. “Бэлэн мөнгөний орлогын баримт”-аар бэлэн мөнгийг тоолж хүлээн авч, зарлагын баримтыг үндэслэн бэлэн мөнгийг хүлээлгэж өгөх. Эдгээр баримтуудыг 2 хувь үйлдэж, мөнгө тушаагч эсвэл хүлээн авагч нарт 1 хувийг өгч, холбогдох баримт бичгийн хамт 1 хувийг нярав хадгалан “Бэлэн мөнгөний тайлан”-д (ДГА-2020/1/СТА-ТӨҮГ)

бичилт хийх үндэслэл болгох. Бэлэн мөнгөний орлого, зарлагын баримтуудыг дагалдах баримт бичгийн хамт Бэлэн мөнгөний тайлангийн 1 хувьтай хавсарган, холбогдох нягтлан бодогчид тушаах. Бэлэн мөнгөний нярав тайлангийн 1 хувийг өөртөө хадгалах.

3.7.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар: